

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1.Аудитын гэрчилгээ	2
2.Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго,үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	8
3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	8
3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	9
3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	12
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН
ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ
УТҮГ-ЫН ЗАХИРАЛ
А.БУЯННЭМЭХ ТАНАА

2020.02.27 № 06/631
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв УТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв УТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудитын тайлан

2.1. Оршил

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв УТҮГ-ын захирал А.Буяннэмэх Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв УТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 2-ноос 2020 оны 2 дугаар сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Баян ташаагийн эх Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 5 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв УТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь галт тэрэгний хөдөлгөөний удирдлага, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох, суурь бүтэц хоорондын галт тэрэгний хөдөлгөөнийг уялдуулан зохицуулахад оршино.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв УТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах;
- Галт тэрэгний хөдөлгөөний удирдлага, зохицуулалтын системийг боловсронгуй болгох;
- Хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт, хангалтыг сайжруулах, тээвэрлэлтийн үйл ажиллагааг бүрэн хянах, хяналт тавих.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах, шилжүүлэх, журам батлах тухай ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоол;
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээ”;
- Монгол улсын Засгийн газрын 2019 оны 25 дугаар тогтоол “Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай”;
- Монгол улсын Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоол “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох”;
- Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 264 дүгээр тушаал “Төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм батлах тухай “

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв УТҮГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ийн Accolous 3.0 программ хангамж ашиглаж байна.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв УТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв УТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 9 эрсдэлтэй асуудалд 9 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгосон дүн 806,322.0 мянган төгрөгөөс тооцон 8,063.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

Материаллаг байдлын түвшинг төлөвлөлтийн үе шатанд 2019 оны жилийн эцсийн нийт зардлын гүйцэтгэлийн дүнгээс тооцоолсон тул гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшин өөрчлөгдөөгүй.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 52,921.7 мянган төгрөгөөр буюу 3.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	
Авлага	8,496.2	8,496.2	-
Урьдчилгаа	-	-	
Бараа материал	23,258.0	21,806.4	(1,451.6)
Үндсэн хөрөнгө	1,727,846.9	1,676,376.8	(51,470.1)
Нийт хөрөнгө	1,759,601.2	1,706,679.5	(52,921.7)
Өр төлбөр	-	-	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,759,601.2	1,706,679.5	(52,921.7)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,759,601.2	1,706,679.5	(52,921.7)

Тухайн онд авлага дансны үлдэгдэл өөрчлөгдөөгүй байна. Үлдэгдэлтэй байгаа авлага нь 2018 онд “Сүмт өргөө” ХХК-д төлсөн түрээсийн төлбөрийн барьцаа 8,436.2 мянган төгрөг, “Юнивишн” ХХК-тай 2 талт гэрээгээр тохиролцсоны дагуу суурилуулсан тоног төхөөрөмжийн барьцаа 60.0 мянган төгрөг тус тус байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,451.6 мянган төгрөгөөр буурсан нь төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмийг хэрэгжүүлэхтэй холбогдон бичиг хэргийн материалын зарцуулалт нэмэгдсэнээс голлон шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд хийсэн тооллогыг ажиглахад ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Тухайн байгууллагын үндсэн хөрөнгөнд нэмэгдсэн, хасагдсан өөрчлөлт гараагүй бөгөөд тухайн жилд 51,470.1 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан нь үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өртөг буурахад нөлөөлсөн байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 753,400.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 749,277.6 мянган төгрөг буюу 99.5 хувьтай байгаа нь тээврийн зардлаас бусад бүх зардал 0.2-оос 4.5 хувиар хэмнэгдэж зарцуулагдсанаас шалтгаалсан байна. Төсвийн санхүүжилтийн үлдэгдэл 4,122.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 9 эрсдэл тодорхойлж нийт 9 горим сорил хэрэгжүүллээ.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв УТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 139 удаагийн мэдээллийг хуулийн хугацаанд нь, 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,358.8 мянган төгрөгийн зөрчилд өгсөн 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэлээ.

“Зөрчилгүй” дүгнэлт

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасны дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3.Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	31,754,248.50	30,302,618.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
33	АВЛАГА	8,496,200.00	8,496,200.00
335	Бусад авлага	8,496,200.00	8,496,200.00
3351	Байгууллагаас авах авлага	8,496,200.00	8,496,200.00
35	БАРАА МАТЕРИАЛ	23,258,048.50	21,806,418.50
351	Түүхий эд материал	20,202,626.50	20,394,116.50
35110	Тусгай зориулалттай материал	20,202,626.50	20,394,116.50
354	Хангамжийн материал	3,055,422.00	1,412,302.00
35410	Бичиг хэргийн материал	2,080,655.00	608,370.00
35460	Хүнсний материал	170,835.00	-
35470	Бусад хангамжийн материал	803,932.00	803,932.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,727,846,933.15	1,676,376,837.09
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,727,846,933.15	1,676,376,837.09
392	Биет хөрөнгө	37,266,933.15	21,748,670.45
39203	Авто-тээврийн хэрэгсэл	57,338,000.00	57,338,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(48,299,301.35)	(57,338,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	43,222,179.00	43,222,179.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,456,994.26)	(31,240,255.51)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,187,687.18	27,187,687.18
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,724,637.42)	(17,420,940.22)
393	Биет бус хөрөнгө	1,690,580,000.00	1,654,628,166.64
39301	Програм хангамж	85,551,000.00	85,551,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(10,331,000.00)	(46,282,833.36)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,615,360,000.00	1,615,360,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,759,601,181.65	1,706,679,455.59
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,759,601,181.65	1,706,679,455.59
51	Засгийн газрын хувь оролцоо	1,759,601,181.65	1,706,679,455.59
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,615,360,000.00	1,615,360,000.00
51101	Өмч: - төрийн	-	-
51102	- хувийн	-	-
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	1,615,360,000.00	1,615,360,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	144,241,181.65	91,319,455.59
51210	Өмнөх үеийн үр дүн	144,241,181.65	144,241,181.65
51220	Тайлант үеийн үр дүн	-	(52,921,726.06)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,759,601,181.65	1,706,679,455.59

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	712,715,100.00	753,400,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	67,700.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	67,700.00	-
120009	Бусад орлого	67,700.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	712,647,400.00	753,400,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	712,647,400.00	753,400,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	712,647,400.00	753,400,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	617,203,008.33	806,322,026.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	617,203,008.33	806,322,026.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	601,521,097.63	799,549,346.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	323,942,210.12	371,669,048.13
210101	Үндсэн цалин	217,206,025.46	252,737,500.00
210102	Нэмэгдэл	89,315,552.13	101,459,247.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,420,632.53	17,472,300.71
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,841,960.31	46,621,600.00
210201	Тэтгэврийн даатгал	26,924,190.79	31,866,024.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,975,103.58	3,688,892.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,685,289.42	2,951,116.00
210204	Ажилгүйдлийн даатгал	798,491.74	737,778.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,458,884.78	7,377,790.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	121,792,846.00	121,822,600.00
210304	Байрны түрээс	121,792,846.00	121,822,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,414,106.33	44,256,638.09
210401	Бичиг хэрэг	15,406,399.00	12,857,425.00
210402	Тээвэр, шатахуун	11,650,000.00	12,444,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,029,353.13	7,794,734.09
210404	Ном, хэвлэл	106,413.20	5,754,280.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,221,941.00	5,405,799.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,456,386.50	26,511,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	464,250.00	19,197,450.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	38,036.50	425,700.00
210604	Урсгал засвар	2,954,100.00	6,887,950.00
2107	Томилолт, зочны зардал	18,490,890.00	18,833,200.00
210702	Дотоод албан томилолт	18,490,890.00	18,833,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,987,766.00	96,729,234.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,788,010.00	47,347,509.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,485,000.00	1,485,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	564,300.00	542,612.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	144,500.00	114,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	45,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	198,000.00	39,907,983.00
210807	Газрын төлбөр	111,056.00	112,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,651,900.00	7,219,630.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,594,932.37	73,105,926.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	990,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,646,200.00	21,635,830.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,958,732.37	51,470,096.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,681,910.70	6,772,679.78
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,550,000.00	2,650,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,550,000.00	2,650,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,131,910.70	4,122,679.78
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,131,910.70	4,122,679.78
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	95,512,091.67	(52,921,726.06)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	95,512,091.67	(52,921,726.06)

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	712,715,100.00	753,400,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	67,700.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	67,700.00	-
120009	Бусад орлого	67,700.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	712,647,400.00	753,400,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	712,647,400.00	753,400,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	712,647,400.00	753,400,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	624,765,400.00	753,400,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	624,765,400.00	753,400,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	609,083,489.30	746,627,620.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	334,360,084.66	371,669,048.13
210101	Үндсэн цалин	227,623,900.00	252,737,500.00
210102	Нэмэгдэл	89,315,552.13	101,459,247.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,420,632.53	17,472,300.71
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,841,960.31	46,621,600.00
210201	Тэтгэврийн даатгал	39,841,960.31	38,668,518.95
210202	Тэтгэмжийн даатгал	-	1,832,231.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	1,465,785.33
210204	Ажилгүйдлийн даатгал	-	769,964.06
210205	Эрүүл мэндийн даатгал	-	3,885,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	121,792,846.00	121,822,600.00
210304	Байрны түрээс	121,792,846.00	121,822,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,045,551.33	42,805,008.09
210401	Бичиг хэрэг	10,684,009.00	11,385,140.00
210402	Тээвэр, шатахуун	11,650,000.00	12,444,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,135,766.33	7,794,734.09
210404	Ном, хэвлэл	7,183,000.00	5,754,280.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,392,776.00	5,426,454.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,029,191.00	26,511,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,415,091.00	19,197,450.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,660,000.00	425,700.00
210604	Урсгал засвар	2,954,100.00	6,887,950.00
2107	Томилолт, зочны зардал	18,490,890.00	18,833,200.00
210702	Дотоод албан томилолт	18,490,890.00	18,833,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,886,766.00	96,729,234.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,788,010.00	47,347,509.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,485,000.00	1,485,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	564,300.00	542,612.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	144,500.00	114,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	45,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	484,000.00	39,907,983.00
210807	Газрын төлбөр	111,056.00	112,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,264,900.00	7,219,630.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,636,200.00	21,635,830.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	990,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,646,200.00	21,635,830.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,681,910.70	6,772,679.78
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,550,000.00	2,650,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,550,000.00	2,650,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,131,910.70	4,122,679.78
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,131,910.70	4,122,679.78
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	87,949,700.00	=

	(3)=(1)-(2)		
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		≡
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	87,949,700.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	87,949,700.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	87,949,700.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	87,949,700.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(87,949,700.00)</u>	≡
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	71,122,515.77	71,122,515.77
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	71,122,515.77	71,122,515.77
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(22,393,425.79)	(22,393,425.79)
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,615,360,000.00	-	144,241,181.65	1,759,601,181.65
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,615,360,000.00	-	144,241,181.65	1,759,601,181.65
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(52,921,726.06)	(52,921,726.06)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,615,360,000.00	-	91,319,455.59	1,706,679,455.59

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	753,400,300.00	749,277,620.22	(4,122,679.78)	99.5
УРСГАЛ ЗАРДАЛ	753,400,300.00	749,277,620.22	(4,122,679.78)	99.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	750,737,000.00	746,627,620.22	(4,109,379.78)	99.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	372,972,700.00	371,669,048.13	(1,303,651.87)	99.6
Үндсэн цалин	252,737,500.00	252,737,500.00	-	100.0
Нэмэгдэл	102,266,700.00	101,459,247.42	(807,452.58)	99.2
Унаа хоолны хөнгөлөлт	17,968,500.00	17,472,300.71	(496,199.29)	97.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,621,600.00	46,621,600.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	31,702,700.00	38,668,518.95	6,965,818.95	122.0
Тэтгэмжийн даатгал	3,729,800.00	1,832,231.66	(1,897,568.34)	49.1
ҮОМШӨ-ний даатгал	2,983,700.00	1,465,785.33	(1,517,914.67)	49.1
Ажилгүйдлийн даатгал	745,900.00	769,964.06	24,064.06	103.2
Эрүүл мэндийн даатгал	7,459,500.00	3,885,100.00	(3,574,400.00)	52.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	121,822,600.00	121,822,600.00	-	100.0
Байрны түрээс	121,822,600.00	121,822,600.00	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	45,150,400.00	42,805,008.09	(2,345,391.91)	94.8
Бичиг хэрэг	11,447,400.00	11,385,140.00	(62,260.00)	99.5
Тээвэр, шатахуун	12,242,100.00	12,444,400.00	202,300.00	101.6
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,363,400.00	7,794,734.09	(4,568,665.91)	63.1
Ном, хэвлэл	5,750,000.00	5,754,280.00	4,280.00	100.1
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,347,500.00	5,426,454.00	2,078,954.00	162.1
Эд хогшил, урсгал засварын зардал	26,516,100.00	26,511,100.00	(5,000.00)	99.9
Багаж, техник, хэрэгсэл	19,736,100.00	19,197,450.00	(538,650.00)	97.3
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,494,800.00	425,700.00	(2,069,100.00)	17.1
Урсгал засвар	4,285,200.00	6,887,950.00	2,602,750.00	160.7
Томилолт, зочны зардал	18,957,400.00	18,833,200.00	(124,200.00)	99.3
Дотоод албан томилолт	18,957,400.00	18,833,200.00	(124,200.00)	99.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	97,008,300.00	96,729,234.00	(279,066.00)	99.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	47,350,000.00	47,347,509.00	(2,491.00)	99.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,485,000.00	1,485,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	564,300.00	542,612.00	(21,688.00)	96.2
Тээврийн хэрэгслийн татвар	257,400.00	114,500.00	(142,900.00)	44.5
Тээврийн хэрэгслийн оношлогоо	45,000.00	-	(45,000.00)	-
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	39,950,000.00	39,907,983.00	(42,017.00)	99.9
Газрын төлбөр	112,000.00	112,000.00	-	100.0
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,244,600.00	7,219,630.00	(24,970.00)	99.7
Бараа үйлчилгээний бусад зардал	21,687,900.00	21,635,830.00	(52,070.00)	99.8
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,687,900.00	21,635,830.00	(52,070.00)	99.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,663,300.00	2,650,000.00	(13,300.00)	99.5
Бусад урсгал шилжүүлэг	2,663,300.00	2,650,000.00	(13,300.00)	99.5
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,663,300.00	2,650,000.00	(13,300.00)	99.5
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	753,400,300.00	749,277,620.22	(4,122,679.78)	99.5
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	753,400,300.00	749,277,620.22	(4,122,679.78)	99.5

Улсын төсвөөс санхүүжих	753,400,300.00	749,277,620.22	(4,122,679.78)	99.5
АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	26	-	-
Удирдах ажилтан	1	1	-	-
Гүйцэтгэх ажилтан	24	25	-	-